

**“КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ
ҮНЭЛЭХ АРГАЧЛАЛ**

Компанийн засаглалын үйл ажиллагааны тайлангийн маягт					
<p>“Компанийн засаглалын кодекс”-ийн зарчмын зүйл тус бүрээр үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайланг дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэнэ.</p> <p>Кодексийн хэрэгжилтийг олон улсад түгээмэл тогтсон “Хэрэгжүүл, эсвэл тайлбарла” гэсэн зарчмын дагуу тайлагнахдаа кодекс дурдсан зарчмын зүйл тус бүрээр биелүүлсэн эсэх, биелүүлээгүй бол яагаад биелүүлээгүй, түүнийг орлох бүтэц, зохион байгуулалтын ямар арга хэмжээ авсныг тайлбар хэсэгт нарийвчлан тайлбарлана.</p>					
НЭГДҮГЭЭР ЗАРЧИМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ					
Төлөөлөн удирдах зөвлөл нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна					
		Хэрэгжилт	Тайлбар	О н о о	Хувь
1	1.1. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмаар төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.	Хэрэгжүүлсэн	ТУЗ-н 2022 оны 11-р сарын 04-ний өдөр ТУЗ-н 03 тоот тогтоолын хавсралтаар “ТУЗ-н үйл ажиллагааны журам”-г боловсруулж баталсан.	2	100
2	1.2. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна.	Хэрэгжүүлсэн	ТУЗ-н 2022 оны 11-р сарын 04-ний өдөр ТУЗ-н 03 тоот тогтоолын хавсралтаар Залгамж халааны бодлогын дүрмийг боловсруулсан.	2	100
3	1.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, өөрийн цахим хуудсанд байршуулна.	Хэрэгжүүлсэн gdacs.mn	Хөрөнгийн биржийн цахим хуудас болон өөрийн компанийн цахим хуудсанд мэдээлэл байршуулдаг.	2	100
4	1.4. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримт бичигтэй байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэр зэрэг асуудлыг тусгана.	Хэрэгжүүлсэн	Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд ТУЗ-н бүтэц, бүрэлдэхүүнийг тусгасан.	2	100

5	<i>1.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.</i>	Хэрэгжүүлсэн	Шинээр томилогдсон гишүүнийг компанийн засаглалын сургалтад хамруулдаг.	2	100
6	<i>1.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.</i>	Хэрэгжүүлсэн	ТУЗ-н даргын чиг үүргийн дор ажлаа хариуцан хийдэг.	2	100
ДҮН				12	100

**ХОЁРДУГААР ЗАРЧИМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД,
ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ**

Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ

7	<i>2.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болоод төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүнбайхыг зорино.</i>		Компаний тухай хуульд нийцүүлж ажиллах	0	0
8	<i>2.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.</i>	Хэрэгжүүлсэн	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал болон ТУЗ тогтоолоор баталсан. ТУЗ-н Аудитын хороон даргаар Хараат бус гишүүн ажилладаг.	2	100
9	<i>2.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно.</i>	Хэрэгжүүлсэн	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал болон ТУЗ тогтоолоор баталсан. ТУЗ-н Цалин урамшууллын хороон даргаар Хараат бус гишүүн ажилладаг.	2	100
10	<i>2.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус, мөн хараат бус гишүүнбайна.</i>	Хэрэгжүүлсэн	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал болон ТУЗ тогтоолоор баталсан. ТУЗ-н Нэр дэвшүүлэх хороон даргаар Хараат бус гишүүн ажилладаг.	2	100

11	2.5. Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршилага бүхий бүрэлдэхүүнтэй байна.	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн	Баримт бичиг боловсруулагдаж байгаа	2	100
ДҮН				8	80
ГУРАВДУГААР ЗАРЧИМ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ					
Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана					
12	3.1. Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Хэрэгжүүлсэн	Компанийн албан ёсны цахим хуудас www.gdacs.mn , МХБ-ийн цахим хуудас www.mse.mn хаягаар хувьцаа эзэмшигч болон олон нийтэд үйл ажиллагаа, санхүүгийн тайланг нээлттэй тайлагнадаг.	2	100
13	3.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.	Хэрэгжүүлсэн	Компанийн албан ёсны цахим хуудас www.gdacs.mn , МХБ-ийн цахим хуудас www.mse.mn хаягаар хувьцаа эзэмшигч болон олон нийтэд үйл ажиллагаа, санхүүгийн тайланг нээлттэй тайлагнадаг.	2	100
14	3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.	Хэрэгжүүлж байгаа	Үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг олон нийтэд нээлттэй байршуулдаг, хөндлөнгийн аудитын дүгнэлтийг тусган оруулдаг.	2	100
ДҮН				6	100

ДӨРӨВДҮГЭЭР ЗАРЧИМ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

Төлөөлөн удирдах зөвлөл нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана

15	4.1. Төлөөлөн удирдах зөвлөл нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, хөндлөнгийн аудиторыг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, журмынхэрэгжилтэд хяналт тавина.	Хэрэгжүүлсэн	ТУЗ-н аудитын хороо хөндлөнгийн аудитыг сонгох боломж нээлттэй, ТУЗ-д танилцуулан баглуулдаг.	2	100
16	4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.	Хэрэгжүүлсэн	Аудитын гаргасан дүгнэлтийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулдаг. МХБ-н цахим хуудсанд дүгнэлтийг байршуулдаг.	2	100
17	4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж тэдгээрт орсон өөрчлөлтийг тухай бүр мэдэгдэнэ.	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн	Цаашид олон нийтэд мэдээллэж ажиллана.	1	50
ДҮН				5	83.3

ТАВДУГААР ЗАРЧИМ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Төлөөлөн удирдах зөвлөл нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина

18	5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина.	Хэрэгжүүлэхээр зорьж байгаа	Баримт бичиг боловсруулагдаж байгаа	1	50
19	5.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана.	Хэсэгчлэн Хэрэгжүүлсэн	2022 оны 11-р сарын 04-ний өдөр ТУЗ -н 03 тоот тогтоолын хавсралтаар Ёс зүйн дүрэмд Эрсдэлийн удирдлагын хорооны үйл ажиллагааны журам боловсруулсан.	1	50
20	5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.	Хэрэгжүүлэхийг зорьж ажиллана	Үйл ажиллагааны тайланд дурьдана	1	50

21	5.4. Компани нь компайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба компайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина.	Хэрэгжүүлсэн	2022 оны 11-р сарын 04-ний өдөр ТУЗ -н тогтоолын хавсралтаар Ёс зүйн дүрэм боловсруулж баталсан	2	100
ДҮН				5	62.5

ЗУРГААДУГААР ЗАРЧИМ. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ					
Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна					
22	<i>6.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.</i>	Хэрэгжүүлсэн	Компанийн дүрэмд зааснаар ТУЗ-н гишүүдийн цалин, урамшууллыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэж баталдаг.	2	100
23	<i>6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримт бичигт тусгана.</i>	Хэрэгжүүлсэн	Хөдөлмөрийн дотоод журамд тусгасан.	2	100
24	<i>6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.</i>	Хэсэгчлэн Хэрэгжүүлсэн	ТУЗ-р баталгаажуулан, хавсралтаар оруулж өгнө.	2	100
ДҮН				6	100
ДОЛООДУГААР ЗАРЧИМ. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ					
Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ					
25	<i>7.1. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.</i>	Хэрэгжүүлж байгаа	Бодлогын баримт бичиг боловсруулагдаж байгаа	1	50
26	<i>7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.</i>	Хэрэгжүүлсэн	Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд тусгасан.	2	100
27	<i>7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.</i>	Хэрэгжүүлсэн	Компанийн цахим хуудсыг үйл ажиллагаандаа ашиглаж, цахим орчинд мэдээллийг нээлттэй байршуулж байна.	2	100
28	<i>7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.</i>	Хэрэгжүүлсэн	Компанийн дотоод журамд тусгасан.	2	100
ДҮН				7	87.5

НАЙМДУГААР ЗАРЧИМ. КОМПАНИЙН СОЁЛ


Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно

29	8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор төлөөлөн удирдах зөвлөл нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Хэрэгжүүлсэн	2022 оны 11-р сарын 04-ний өдөр ТУЗ -н 03 тоот тогтоолын хавсралтаар Ёс зүйн дүрэм боловсруулж баталсан	2	100
30	8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг төлөөлөн удирдах зөвлөл, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх “шүгэл үлээгчийн” тогтолцоотой байна.	Хэрэгжүүлэхийг зорино	Холбогдох хууль гарахыг хүлээж байна	1	50
31	8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.	Хэрэгжүүлэхийг зорино.	Ёс зүйн дүрэмд тусгаж өгнө.	1	50
ДҮН				4	66.6


ЕСДҮГЭЭР ЗАРЧИМ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ					
Компани болон төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана					
32	9.1. Компани хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талуудад зориулан өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа дамжуулан тухай бүр хүргэнэ.	Хэрэгжүүлсэн	Компани хагас, бүтэн жилээр үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан гаргаж өөрийн цахим хуудас, МХБ-н цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж байна.	2	100
33	9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба хөрөнгө оруулагчидтай харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.	Хэрэгжүүлсэн	Цахим хуудсаар дамжуулан мэдээлэл өгдөг. Цаашид хөтөлбөрийг бэлтгэн ажиллахыг зорино.	2	100
34	9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.	Хэрэгжүүлсэн	Хувьцаа эзэмшигчид хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах бүрэн боломжтой.	2	100
35	9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтэцтэй холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.	Хэрэгжүүлсэн	Нээлттэй хувьцаат компанийн хувьд хувьцаа эзэмшигч эрхээ хэрэгжүүлэхэд ямар нэг асуудал гараагүй болно.	2	100
36	9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн нийтлэг ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба түүний хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.	Хэрэгжүүлсэн	ТУЗ-н дэргэдэх аудитын хороо сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавьж дүгнэлт гаргана.	2	100
ДҮН				10	100
НЭГДСЭН ДҮН				63	87.5

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:
ТУЗ-н ердийн гишүүн

ТАЙЛАНГ ХЯНАЖ БАТАЛСАН:
ТУЗ-н Дарга



Д.Гантуул



Т.Төгс-Од